




СҮХБААТАР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС



2025 V

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



www.1212.mn



www.sukhbaatar.nso.mn

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН САРЫН
ТАНИЛЦУУЛГА

2025
5 сар

Баруун-Урт сум

ЕРӨНХИЙ ТЭМДЭГЛЭЛ

I. Товчилсон үгийн тайлал.

- Сумдын нэр:

АС Асгат	ТШ Түвшинширээ
БД Баяндэлгэр	ТЦ Түмэнцогт
ДА Дарьганга	УБ Уулбаян
МХ Мөнххаан	ХА Халзан
НА Наран	ЭЦ Эрдэнэцагаан
ОН Онгон	БУ Баруун-Урт
СҮ Сүхбаатар	
- 'Төл' гэсэн нь төлөвлөгөө, 'Гүйц' гэсэн нь гүйцэтгэл юм.

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-X ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав)

III. Дараах тэмдэглэлийг ашиглав.

...	Мэдээлэл байхгүй	-	Гүйцэтгэл байхгүй
0.0	Маш бага тоо	*	Урьдчилсан гүйцэтгэл
¹	Дахин		

a^x x нь өмнөх оны мөн үетэй харьцуулсан цэвэр өсөлт, бууралтын хувь өөрчлөлт

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ.

- | | | | |
|----------|------------------|-------------------|------------------|
| • мянга | =1000 | • м ² | метр квадрат |
| • сая | =10 ⁶ | • км ² | километр квадрат |
| • тэрбум | =10 ⁹ | • м ³ | метр куб |
| • см | сантиметр | • мл | миллилитр |
| • дм | дециметр | • л | литр |
| • м | метр | • г | грамм |
| • км | километр | • кг | килограмм |
| • мян. | мянга | • цн | центнер |
| • % | хувь | • т | тонн |
| • кВт.ц | киловатт цаг | • ш | ширхэг |
| • ккал | килокалори | | |

┌ "Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

V. Орон дэвшүүлэхээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас их, бага зэрэг зөрүүтэй байж болно.

ГАРЧИГ

	Ерөнхий тэмдэглэл		2
	Үндсэн үзүүлэлтүүд		4
I	Хүн ам		6
II	Хөдөлмөр		7
III	Нийгмийн халамж		8
IV	Эрүүл мэнд		9
V	Гэмт хэрэг		11
VI	Мөнгө, банк		12
VII	Орон нутгийн төсөв		13
VIII	Үнэ		14
IX	Мал аж ахуй		18
X	Аж үйлдвэр		22
	Хавсралт хүснэгтийн жагсаалт		26
	Хавсралт хүснэгтүүд		27

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 5 дугаар сарын байдлаар

Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Жил			Сар			Өөрчлөлт	
		2022	2023	2024	2023 I-V	2024 I-V	2025 I-V	Дүн	Хувь
ХӨДӨЛМӨР									
Бүртгэлтэй ажилгүй иргэд	хүн	363	302	234	-	175	283	108	61.7
НИЙГМИЙН ХАЛАМЖ									
Нийгмийн халамжийн үйлчилгээнд олгосон мөнгөн дүн, санхүүжилт	сая.төг	11 093.1	13 019.8	16 461.7	5 040.7	6 710.1	8 321.3	1 611.2	24.0
Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид	хүн	27 369	29 221	29 423	22 792	23 408	19 023	-4 385	- 18.7
ЭРҮҮЛ МЭНД									
Амьд төрсөн хүүхэд	хүн	1 110	1 213	955	545	451	362	- 89	- 19.7
Амаржсан эх	хүн	1 112	1 209	949	542	448	361	- 87	- 19.4
Нас баралт	хүн	294	298	336	142	130	128	- 2	- 1.5
1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	хүн	9	6	7	3	3	5	2	66.7
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	хүн	4	5	3	3	2	1	- 1	- 50.0
Халдварт өвчнөөр өвчлөгчид	хүн	5 369	924	617	562	380	466	86	22.6
ГЭМТ ХЭРЭГ									
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	511	456	497	219	215	287	72	33.5
Хэрэгт холбогсод	хүн	409	328	343	98	141	133	- 8	- 5.7
МӨНГӨ, БАНК									
Иргэдийн хадгаламж	тэрбум төгрөг	133.9	145.2	175.5	140.0	158.9	177.6	18.7	11.8
Зээлийн өрийн үлдэгдэл	тэрбум төгрөг	191.6	232.1	307.6	202.8	256.6	319.4	62.8	24.5
ОРОН НУТГИЙН ТӨСӨВ									
Орон нутгийн төсвийн орлого	тэрбум төгрөг	62.9	82.8	103.3	33.1	35.1	35.3	0.2	0.6
Орон нутгийн төсвийн зарлага	тэрбум төгрөг	52.0	64.5	83.8	18.5	27.7	31.9	4.2	15.2
ҮНЭ									
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, оны эцэстэй харьцуулснаар, хувиар	хувь	12.7	7.1	7.6	4.1	3.0	2.6	- 0.4	-
АЖ ҮЙЛДВЭР									
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн *	тэрбум төгрөг	149.8	221.3	301.4	81.7	96.4	122.7	26.3	27.3
Борлуулсан бүтээгдэхүүн *	тэрбум төгрөг	322.8	432.1	447.7	197.6	135.3	173.7	38.4	28.4

Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Жил			Сар			Өөрчлөлт	
		2022	2023	2024	2023 I-V	2024 I-V	2025 I-V	Дүн	Хувь
МАЛ АЖ АХУЙ									
Төллөсөн хээлтэгч	мян.тол	1 564.3	1 548.8	554.4	1 517.3	528.8	710.7	181.9	34.4
Гүү	мян.тол	93.2	90.2	46.1	75.4	32.9	51.0	18.1	54.9
Үнээ	мян.тол	98.8	94.4	42.6	78.4	31.4	31.9	0.5	1.6
Ингэ	мян.тол	1.5	1.3	0.9	1.0	0.7	0.7	0.0	-0.6
Эм хонь	мян.тол	870.2	874.9	312.6	874.5	312.0	350.0	38.0	12.2
Эм ямаа	мян.тол	500.6	488.1	152.2	487.9	151.8	277.1	125.3	82.5
Бойжуулсан төл, бүгд	мян.тол	1 552.6	1 102.9	446.8	1 108.4	423.3	711.0	287.7	68.0
Унага	мян.тол	92.5	71.6	43.3	59.3	30.5	50.9	20.4	66.9
Тугал	мян.тол	98.1	78.3	40.1	64.3	29.0	31.9	2.9	10.0
Ботго	мян.тол	1.5	1.2	0.8	1.0	0.7	0.7	0.0	3.7
Хурга	мян.тол	865.2	624.1	246.9	642.4	247.2	350.2	103.0	41.7
Ишиг	мян.тол	495.2	327.7	115.7	341.4	115.9	277.3	161.4	24**
Том малын зүй бус хорогдол	мян.тол	15.8	578.4	1 824.9	552.2	1 815.5	2.5	-1 813.0	-99.9
Адуу	мян.тол	1.7	27.2	72.9	25.4	71.5	0.5	-71.0	-99.3
Үхэр	мян.тол	1.7	30.4	135.8	28.2	135.0	0.2	-134.8	-99.9
Тэмээ	мян.тол	0.0	0.1	0.3	0.1	0.3	-	-0.3	-
Хонь	мян.тол	6.1	272.5	1 067.1	260.5	1 061.6	0.9	-1 060.7	-99.9
Ямаа	мян.тол	6.3	248.1	548.8	238.0	547.1	0.9	-546.2	-99.8

Тайлбар: ** дахин




ХҮН АМ

Төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 19.7 хувиар буурсан байна.


Эрүүл мэндийн газраас гаргадаг мэдээллээр 2025 оны эхний 5 дугаар сарын байдлаар 361 эх амаржиж, 362 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 87 (19.4%)-аар, төрсөн хүүхэд 89 (19.7%)-аар тус тус буурчээ.

ЗУРАГ 1. ТӨРӨЛТ, жил бүрийн эхний 5 дугаар сарын байдлаар



1000 хүнд ногдох төрөлт өмнөх оны мөн үеэс 1.3 нэгж хувиар буурсан байна.

ЗУРАГ 2. НАС БАРАЛТ, жил бүрийн эхний 5 дугаар сарын байдлаар



2025 оны эхний 5 дугаар сарын байдлаар нас баралт 128 болж, өмнөх оны мөн үеэс 2 (1.5%)-аар буурчээ. 1000 хүнд ногдох төрөлт 5.5, нас баралт 1.9, ердийн цэвэр өсөлт 3.5 байна.

1000 хүнд ногдох нас баралт өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар буурсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Хүн амын ердийн цэвэр өсөлт нь төрөлт, нас баралтын зөрүүгээр тодорхойлно.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар



ХӨДӨЛМӨР


Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо өмнөх сараас 68.5 хувиар өсжээ.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо 2025 оны 5 дугаар сарын эцэст 283 болсны 135 (47.7%) нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгэлтэй ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 108 (61.7%) хүнээр өссөн, 2024 оны 12 дугаар сараас 49 (20.9%) тус тус өссөн байна.

2025 оны эхний 5 дугаар сарын байдлаар Хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт 716 ажилгүй иргэн шинээр бүртгүүлсний 401 иргэн ажилд зуучлагдан орсон байна.

ЗУРАГ 3.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙГУУЛЛАГАД ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН БОЛОН АЖИЛД ЗУУЧЛАГДАН ОРСОН ИРГЭД, ЖИЛ БҮРИЙН ЭХНИЙ 5 ДУГААР САРЫН БАЙДЛААР



Ажилгүй иргэдийн 187 (66.1%) нь 15-44 насныхан эзэлж байгаа юм.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 3 (1.1%) нь магистр, доктор, 37 (13.1%) нь бакалавр, 10 (3.5%) нь тусгай мэргэжлийн дунд, 9 (3.2%) нь мэргэжлийн анхан шат, 122 (43.1%) нь бүрэн дунд, 64 (22.6%) нь суурь, 29 (10.2%) нь бага, 9 (3.2%) боловсролгүй хүмүүс байна.

ЗУРАГ 4.

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, БОЛОВСРОЛЫН ТҮВШНЭЭР, 2025 ОНЫ 5 ДУГААР САРЫН ЭЦЭСТ



Ойлголт, тодорхойлолт:

Хөдөлмөр: Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн хүмүүс орсон болно.

Эх үүсвэр: Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын бүртгэлтэй ажилгүй иргэдийн сарын мэдээ



НИЙГМИЙН ХАЛАМЖ

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 674 хүн хамрагдсан нь өмнөх оноос 11 (1.6%) хүнээр буурчээ.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр 2025 оны эхний 5 дугаар сарын байдлаар нийгмийн халамжийн тэтгэвэрт 1.5 мянган хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 32 (2.2%) хүнээр, олгосон тэтгэврийн хэмжээ 2.9 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 0.5 (18.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэмжид 2025 оны эхний 5 дугаар сарын байдлаар 2.8 мянган хүн хамрагдсаны 50.6 хувь нь асаргааны тэтгэмжид, 49.4 хувь нь онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид хамрагдсан иргэд байна.

2025 оны эхний 5 дугаар сард нийгмийн халамжийн үйлчилгээнд нийт 8.3 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 1.6 (24.0%) тэрбум төгрөгөөр өсөж, 19.0 мянган хүн нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 4.4 (18.7%) мянган хүнээр буурсан байна.

ХҮСНЭГТ 1. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАГЧИД, ТӨРЛӨӨР

Үзүүлэлт	Жил				Сар				Өөрчлөлт	
	2023		2024		2024 I-V		2025 I-V			
	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг	Дүн	Хувь
Бүгд	29 221	13 019.8	29 423	16 461.7	23 408	6 710.1	19 023	8 321.3	1 611.2	24.0
Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, үйлчилгээ	5 310	8 668.4	5 661	12 058.4	4 608	4 623.1	4 974	5 569.1	946.0	20.5
Нийгмийн халамжийн тэтгэвэр	1 528	5 025.4	1 578	6 233.2	1 454	2 448.2	1 486	2 899.8	451.6	18.4
Нийгмийн халамжийн тэтгэмж	2 641	3 445.2	3 063	5 650.8	2 469	2 135.6	2 814	2 629.3	493.7	23.1
Нийгмийн хөгжлийн үйлчилгээ	179	88.7	332	80.2	685	39.3	674	40.0	0.7	1.7
Алдар эхийн одонгийн мөнгөн урамшуулал	962	109.1	688	94.3	5 697	732.9	5 848	1 486.8	753.9	2.0 ¹
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	5 800	748.0	5 967	759.9	5 061	106.8	472	87.9	-18.9	-17.7
Алдар цолтон амхад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт	7 600	538.8	7 360	591.3	6	0.9	5	0.7	-0.2	-22.2
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	37	6.6	32	5.4	450	87.5	375	70.5	-17.0	-19.4
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	1 152	220.9	1 261	287.7	4 248	895.2	3 729	825.2	-70.0	-7.8
Насны хишиг	6 068	2 337.2	5 451	2 221.9	3 338	263.7	3 620	281.1	17.4	6.6

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 674 хүн хамрагдсан нь өмнөх оноос 11 (1.6%) хүнээр буурсан нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдах өрхийг тодорхойлох журмаа өөрчилсөнтэй холбоотой.

Халамжаас хөдөлмөрт гэсэн бодлого хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд Асгат, Наран, Сүхбаатар, Халзан, Түвшинширээ, Түмэнцогт, Уулбаян сумд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдахаа байсан.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын халамжийн сарын мэдээ



ЭРҮҮЛ МЭНД

2025 оны эхний 5 дугаар сарын байдлаар улаан бурхан өвчний 64 тохиолдол бүртгэгджээ.

Эрүүл мэндийн газрын мэдээллээр 2025 оны эхний 5 дугаар сарын байдлаар 361 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 87 (19.4%) эхээр буурсан байна.

Нийт амьд төрсөн хүүхдийн 307 (85.0%) нь төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амласан, 14 (3.9%) нь 2500 граммаас бага жинтэй байна.

ХҮСНЭГТ 2. АМАРЖСАН ЭХ, ТӨРСӨН ХҮҮХЭД, жил бүрийн эхний 5 дугаар сарын байдлаар

Үзүүлэлт	Жил			Сар			Өөрчлөлт	
	2022	2023	2024	2023 I-V	2024 I-V	2025 I-V		
	Тоо						Дүн	Хувь
Амаржсан эх	1 112	1 209	949	542	448	361	- 87	-19.4
б, түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан	1 054	1 173	892	528	425	336	- 89	-20.9
Гэрийн төрөлт	2	4	2	3	2	1	- 1	-50.0
Амьд төрсөн хүүхэд	1 110	1 213	955	545	451	362	- 89	-19.7
1 цагийн дотор хөхөө амласан хүүхэд	1 017	1 155	879	514	412	307	- 105	-25.5
Төрөлхийн гажигтай төрсөн	7	8	9	3	5	2	- 3	-60.0
2500 граммаас доош жинтэй төрсөн	37	37	28	13	17	14	- 3	-17.6
Амьгүй төрсөн хүүхэд	5	4	2	2	-	2	2	-
Амьгүй төрөлтийн түвшин / 1000 нийт төрөлтөд ногдох/	4.5	3.3	2.1	3.7	-	5.5	5.5	-

2025 оны эхний 5 дугаар сарын байдлаар нас баралтын 128 тохиолдол бүртгэгдсэний 13 (10.2%) нь осол гэмтлийн улмаас, 49 (38.3%) нь хорт хавдрын өвчлөлийн улмаас нас барсан байна.

ХҮСНЭГТ 3. НАС БАРАЛТ, зарим үзүүлэлтээр, жил бүрийн эхний 5 дугаар сарын байдлаар

Үзүүлэлт	Жил			Сар			Өөрчлөлт	
	2022	2023	2024	2023 I-V	2024 I-V	2025 I-V		
	Тоо						Дүн	Хувь
Нас баралт	294	298	336	142	130	128	-2	-1.5
Эмнэлгийн нас баралт	55	50	70	23	27	22	-5	-18.5
Эхийн эндэгдэл	1	1	1	-	1	-	-1	-
Осол гэмтэлийн өвчлөл нас баралт	36	53	44	29	17	13	-4	-23.5
Хорт хавдрын өвчлөл нас баралт	90	79	107	30	31	49	18	58.1
0-1 насны эндэгдэл	9	6	7	3	3	5	2	66.7
1-5 хүртэлх насны эндэгдэл	4	5	3	3	2	1	-1	-50.0

Халдварт өвчнөөр өвчлөгчид 2025 оны эхний 5 дугаар сарын байдлаар 466 болж, өмнөх оны мөн үеэс 86 (22.6%)-аар өссөн байна.

ХҮСНЭГТ 4. ХАЛДВАРТ ӨВЧИН, өвчний төрлөөр, жил бүрийн эхний 5 дугаар сарын байдлаар

Халдварт өвчин	Жил			Сар			Өөрчлөлт	
	2022	2023	2024	2023 I-V	2024 I-V	2025 I-V	Дүн	Хувь
	Хүн							
Бүгд	5 369	924	617	562	380	466	86	22.6
Вируст гепатит	6	4	2	2	1	-	-1	
Цусан суулга	20	32	14	2	9	9	-	-
Гахайн хавдар	-	2	1	2	1	-	-1	-
Бруцеллөз	2	-	1	-	1	-	-1	-
Салхинцэцэг	140	222	151	175	128	200	72	56.3
Энтервируст халдвар	-	149	83	77	70	1	-69	-98.6
Улаан эсэргэнэ	-	14	-	12	-	2	2	-
Ecoli-оор/ A04.4/	-	-	14	-	3	-	-3	-
Ёлом	-	1	-	1	-	3	3	-
Салмонеллт	-	30	27	1	10	5	-5	-50.0
Гар хөл амны өвчин	100	126	102	106	78	42	-36	-46.2
Тархины феомикоз буглаа	-	-	1	-	-	-	-	-
Хачигт	-	4	1	4	-	-	-	-
Халдварт эритема /B08.3/	-	-	-	-	-	33	33	-
Сүрьеэ	60	55	54	32	23	29	6	26.1
Тэмбүү	53	34	47	15	15	31	16	2.1 ¹
Заг	81	49	78	21	28	35	7	25.0
Трихоминиаз	87	59	41	29	13	11	-2	-15.4
Ковид-19	4 820	143	-	83	-	-	-	-
Улаан бурхан	-	-	-	-	-	64	64	-
Менингококкт	-	-	-	-	-	1	1	

Халдварт өвчний тохиолдлуудаас салхинцэцгээр 72 (56.3%)-аар, сүрьеэ 6 (26.1%), заг хүйтнээр өвчлөгчид 7 (25.0%)-аар, тэмбүү 16 (2.1 дахин)-оор нэмэгдсэн нь өндөр өсөлтэй байна.

Шинээр халдварт улаан бурхан өвчний 64, менингококкт 1 тохиолдол бүртгэгджээ.

Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 5 дугаар сарын байдлаар 122.7 мянган хүнд үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 7.9 (6.8%) мянган хүнээр өсөж, 7.0 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн байна. Урьдчилан сэргийлэх үзлэгт 29.3 мянган хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 11.3 (63.1%) мянган хүнээр өсжээ.

Түргэн тусламжийн дуудлага 6.5 мянган удаа гарсны 0.8 (13.0%) мянга нь алсын дуудлага байгаа нь өмнөх оны мөн үеэс 722 (46.0%) удаагийн дуудлагаар буурсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар



ГЭМТ ХЭРЭГ

Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 72 (33.5%)-оор өссөн байна.


2025 оны эхний 5 дугаар сарын байдлаар 287 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд гэмт хэргийн улмаас 18 хүн нас барж, 57 хүн гэмтэж бэртсэн байна. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 983.1 сая төгрөгийн хохирол учирсны 10.3 хувийг нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 133 хүн холбогдон сэжиглэгдсэний 87 (65.4%) хүн нь согтуугаар, 10 (7.5%) хүн нь бүлгээр гэмт хэрэг үйлджээ.

2025 оны эхний 5 дугаар сарын байдлаар нийт 23 хүн эрүүлжүүлэгдсэн байна. Шүүхийн шийдвэрээр 73 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.

Аймгийн хэмжээнд нийт 287 гэмт хэргээс, илрүүлэлт 34.0 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 17.9 нэгжээр буурсан байна.

ЗУРАГ 5. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО



Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай" хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Цагдаагийн газрын бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ



МӨНГӨ ЗЭЭЛ


Чанаргүй хугацаа хэтэрсэн зээл 2025 оны 5 дугаар сарын эцэст 1.9 тэрбум болж, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.6 хувийг эзэлж байна.

2025 оны 5 дугаар сарын эцэст Сүхбаатар аймаг дахь Монгол банкны салбарын мэдээллээр ХААН, Төрийн, Хас, Голомт банкнуудаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 319.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх сараас 2.4 (0.8%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 63.1 (24.6%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Банкнүүдэд хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 177.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх сараас 4.2 (2.3%) тэрбум төгрөгөөр буурсан, харин өмнөх оны мөн үеэс 18.7 (11.8%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийт хадгаламжийн 84.6 хувь нь хугацаатай, 15.4 хувь нь хугацаагүй хадгаламж байна.

ЗУРАГ 6. ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, тэрбум төгрөг



Ойлголт, тодорхойлолт:

Хэвийн зээл: Төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Хугацаа хэтэрсэн зээл: Зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Чанаргүй зээл: Хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Эх үүсвэр: Сүхбаатар аймаг дахь Монголбанкны салбар, Банкны салбарын мэдээ




ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Орон нутгийн төсвийн орлого өмнөх оны мөн үеэс 0.7 хувиар өсжээ.

Аймгийн төсвийн нийт орлого 2025 оны эхний 5 дугаар сарын байдлаар 35.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 0.2 (0.7%) тэрбум төгрөгөөр, төсвийн зарлага санхүүжилт 31.9 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 4.2 (15.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 7. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, тэрбум төгрөг



Аймгийн нийт төсвийн 46.9 хувийг орон нутгийн төсвийн орлого, 26.4 хувийг улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, 12.9 хувийг аймгаас авсан санхүүгийн дэмжлэг, 12.0 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг, 0.2 хувийг урьд оны үлдэгдэл, 1.6 хувийг төсөвт байгууллагын орлого тус тус эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Төрийн санхүү: Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ.

Аймгийн нэгдсэн төсөв нь татварын болон татварын бус орлого, улсаас авах санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого, орон нутгийн сангийн орлогын шилжүүлэг зэргээс бүрдэнэ.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн боловсруулсан аймгийн төсвийн мэдээ.




ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.1 хувиар өслөө.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2025 оны 5 дугаар сард аймгийн хэмжээнд өмнөх оны мөн үеэс 7.6 хувь, өмнөх оны эцсээс 2.6 хувь, өмнөх сараас 0.1 хувиар өссөн байна.

ЗУРАГ 8.

ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үеэс), сараар, хувиар



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2025 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеэс 7.6 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 1.6 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 30.6 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 7.9 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ дүнгээрээ 4.3 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 2.7 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.8 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 12.9 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 65.0 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 7.1 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2025 оны 5 дугаар сард өмнөх оны эцсээс 2.6 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 4.1 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 1.0 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 3.1 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 1.1 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 3.0 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээний бүлгийн үнэ 65.0 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 7.7 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2025 оны 5 дугаар сард өмнөх сараас 0.1 хувиар өсөхөд согтууруулах ундаа, тамхины бүлгийн дүнгээрээ 0.2 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 0.1 хувь, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлгийн үнэ 0.5 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 3.9 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.


ХҮСНЭГТ 5.

ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, 2025 оны 5 дугаар сард

Бараа үйлчилгээний бүлэг	$\frac{2025 \text{ V}}{2024 \text{ V}}$	$\frac{2025 \text{ V}}{2024 \text{ XII}}$	$\frac{2025 \text{ V}}{2025 \text{ IV}}$
	хувь		
Ерөнхий индекс	7.6	2.6	0.1
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	1.6	4.1	-0.8
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	-1.2	1.0	0.2
Хувцас, бөс бараа, гутал	30.6	3.1	0.0
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	7.9	1.1	0.1
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	4.3	0.0	0.0
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	2.7	0.2	0.5
Тээвэр	-1.4	0.0	0.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	0.8	0.0	0.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	-0.7	-2.1	0.0
Боловсролын үйлчилгээ	0.0	0.0	0.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	12.9	3.0	0.0
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	65.0	65.0	0.0
Бусад бараа, үйлчилгээ	7.1	7.7	3.9

ЗУРАГ 9.

МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), сараар, хувиар



Мах, махан бүтээгдэхүүний үнэ 2025 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеэс 9.5 хувиар өсөхөд үхрийн мах 4.5 хувь, хонь, ямааны мах 18.1 хувь, адууны мах 2.9 хувь, гахайн мах 39.7 хувиар тус тус өссөн, мөн 2024 оны эцсээс 18.5 хувиар өсөхөд үхрийн мах 19.4 хувь, хонь, ямааны мах 35.6 хувь, адууны мах 26.6 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Ойлголт, тодорхойлолт:

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.



ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ

Хязаалан гунан үхрийн үнэ Мөнххаан суманд хамгийн өндөр буюу 2.9 сая төгрөг байна.

Малын зах зээлийн дундаж үнийн 2025 оны 5 дугаар сарын мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад атны үнэ 1.2 сая төгрөг болж, 187.5 мянган төгрөгөөр, соёолон үрээний үнэ 1.1 сая төгрөг болж, 87.5 мянган төгрөгөөр, хязаалан гунан үхрийн үнэ 2.0 сая төгрөг болж, 692.5 мянган төгрөгөөр, эр хонины үнэ 285.4 мянган төгрөг болж, 52.5 мянган төгрөгөөр, эр ямааны үнэ 176.7 мянган төгрөг болж, 30.4 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 6.


НАС ГҮЙЦСЭН МАЛЫН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 5 дугаар сард

Төрөл	2022 V	2023 V	2024 V	2025 V	Өөрчлөлт	
	мян.төг				Дүн	Хувь
Нас гүйцсэн ат	1 250.0	1 125.0	975.0	1 162.5	187.5	19.2
Соёолон үрээ	1 039.1	995.5	983.3	1 070.8	87.5	8.9
Хязаалан гуна	1 527.3	1 559.1	1 320.0	2 012.5	692.5	52.5
Эр хонь	212.3	202.3	232.9	285.4	52.5	22.5
Эр ямаа	158.5	130.8	146.3	176.7	30.4	20.8

Хязаалан гунан үхрийн үнэ 2025 оны 5 дугаар сард Мөнххаан суманд хамгийн өндөр буюу 2.9 сая төгрөг, Түвшинширээ суманд хамгийн бага буюу 1.1 сая төгрөг байна.

ЗУРАГ 10.


НАС ГҮЙЦСЭН ЭР ҮХРИЙН ДУНДАЖ ҮНЭ, 2025 оны 5 дугаар сард, мянган төгрөгөөр



Ноолуурын үнэ 2025 оны 5 дугаар сард 90.0 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25.0 (21.7%) мянган төгрөгөөр, боодолтой өвсний дундаж үнэ 3.3 мянган төгрөг болж өмнөх оны мөн үеэс 4.7 (59.4%) мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

ЗУРАГ 11.

МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 5 дугаар сард, төгрөгөөр



Ойлголт, тодорхойлолт:

Малын үнийн мэдээнд хүнсний болон ашиг шим, уналга, эдэлгээний зориулалтаар худалдан борлуулсан малын үнийг хамруулах бөгөөд харин шилмэл омгийн мах, сүүний чиглэлийн, хурдны морь зэрэг өндөр үнээр борлуулсан малын үнийг үнийн мэдээнд хамруулахгүй.

Тооцох аргачлал: Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, аймгийн худалдааны цэг, ченжүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.



МАЛ АЖ АХУЙ

Мал төллөлт 2025 оны эхний 5 дугаар сарын байдлаар аймгийн хэмжээнд 69.0 хувьтай байна.

Сүхбаатар аймгийн хэмжээнд 2025 оны эхний 5 дугаар сарын байдлаар оны эхний төллөх насны 1.0 сая хээлтэгч малын 710.7 (69.0%) мянга нь төллөжээ. Гүүний 44.7 хувь, үнээний 38.8 хувь, ингэний 27.7 хувь, эм хонины 75.6 хувь, эм ямааны 75.2 хувь нь төллөсөн байна.


ХҮСНЭГТ 7.

МАЛ ТӨЛЛӨЛТ, ТӨРЛӨӨР

Малын төрөл	Оны эхний хээлтэгч			Төллөсөн хээлтэгч			Төллөлтийн хувь		
	2023	2024	2025	2023 I-V	2024 I-V	2025 I-V	2023 I-V	2024 I-V	2025 I-V
	мянган толгой						хувь		
Дүн	2 063.7	1 859.6	1 030.8	1 517.3	528.8	710.7	73.5	28.4	69.0
Адуу	128.1	127.5	114.1	75.4	32.9	51.0	58.9	25.8	44.7
Үхэр	134.9	127.2	82.3	78.5	31.4	31.9	58.2	24.7	38.8
Тэмээ	3.1	3.0	2.5	1.0	0.7	0.7	34.1	23.1	27.7
Хонь	1 130.5	1 027.5	463.3	874.5	312.0	350.0	77.4	30.4	75.6
Ямаа	667.2	574.3	368.6	487.9	151.8	277.1	73.1	26.4	75.2

ЗУРАГ 12.

ОНЫ ЭХНИЙ ХЭЭЛТЭГЧ МАЛ, ТӨЛЛӨЛТ, МЯНГАН ТОЛГОЙ



Бойжуулсан төл 2025 оны эхний 5 дугаар сарын байдлаар 711.0 мянга болж, бойжилтын хувь 99.8% байна. Гарсан унаганы 99.9 хувь, тугалын 99.9 хувь, ботгоны 99.9 хувь, хурганы 99.8 хувь, ишигний 99.8 хувь нь бойжжээ. Аймгийн хэмжээнд 1.2 мянган толгой төл мал хорогдсоныг төрлөөр нь авч үзвэл: унага 54, тугал 41, ботго 1, хурга 546, ишиг 540 толгой төл мал тус тус хорогдоод байна.

ХҮСНЭГТ 8.

БОЙЖУУЛСАН ТӨЛ, төлийн төрлөөр, жил бүрийн эхний 5 дугаар сарын байдлаар, мянган толгой

Төлийн төрөл	Гарсан төл			Бойжуулсан төл			Төл бойжилтын хувь		
	2023 I-V	2024 I-V	2025 I-V	2023 I-V	2024 I-V	2025 I-V	2023 I-V	2024 I-V	2025 I-V
Дүн	1520.4	529.2	712.1	1 108.4	423.3	711.0	72.9	80.0	99.8
Унага	75.4	32.9	51.0	59.3	30.5	50.9	78.6	92.7	99.9
Тугал	78.4	31.4	31.9	64.3	29.0	31.9	82.0	92.6	99.9
Ботго	1.0	0.7	0.7	1.0	0.7	0.7	94.9	94.4	99.9
Хурга	876.2	312.2	350.7	642.4	247.2	350.2	73.3	79.2	99.8
Ямаа	1 108.4	152.0	277.9	341.4	115.9	277.3	69.8	76.2	99.8

Сүхбаатар аймгийн хэмжээнд 2025 оны эхний 5 дугаар сарын байдлаар оны эхний малын 0.1 хувь буюу 2.5 мянган толгой мал хорогдоод байна. Нийт хорогдлыг төрлөөр нь авч үзвэл адуу 501 толгой, үхэр 245 толгой, хонь 926 толгой, ямаа 869 толгой мал тус тус хорогдсон байна.

ХҮСНЭГТ 9.


ХОРОГДСОН ТОМ МАЛ, төрлөөр, жил бүрийн эхний 5 дугаар сарын байдлаар

Малын төрөл	Хорогдсон том мал			Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь		
	2023 I-V	2024 I-V	2025 I-V	2023 I-V	2024 I-V	2025 I-V
	мянган толгой			хувь		
Дүн	552.2	1 815.5	2.5	11.9	47.0	0.1
Адуу	25.4	71.5	0.5	6.3	19.5	0.2
Үхэр	28.2	135.0	0.2	8.3	44.5	0.1
Тэмээ	0.1	0.3	-	1.2	4.0	-
Хонь	260.5	1 061.6	0.9	10.8	50.2	0.1
Ямаа	238.0	547.1	0.9	36.9	47.1	0.1


Нийт хорогдсон малын 36.4 хувийг хонь, 34.2 хувийг ямаа эзэлж байна. Хорогдлыг сумдаар нь авч үзэхэд 2025 оны эхний 5 дугаар сард Баруун-Урт суманд 429 (16.9 хувь), Мөнххаан суманд 493 (19.4 хувь), Асгат суманд 249 (9.8 хувь), Сүхбаатар суманд 285 (11.2 хувь), Дарьганга суманд 392 (15.4 хувь), Түмэнцогт суманд 227 (8.9 хувь) толгой мал хорогдсон нь нийт хорогдлын 81.6 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 13.

ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, сумдаар



ЗУРАГ 14. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, төрлөөр



2025 оны эхний 5 дугаар сарын байдлаар 17 толгой хээлтүүлэгч, 639 толгой хээлтэгч, 1.9 мянган толгой таваарын мал хорогдоод байна.

Ойлголт, тодорхойлолт:

Том малын зүй бус хорогдол: Гэнэтийн аюулаар буюу байгалийн аюулт үзэгдэл, өвчнөөр хорогдсон (халдвартай, халдваргүй), зэрлэг амьтанд идүүлсэн, бариулсан ба бусад шалтгаанаар хорогдсон төл малаас бусад малыг оруулна.

Оны эхний малд том малын зүй бус хорогдлын эзлэх хувь: Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.

ГАЗАР ТАРИАЛАН




2025 оны эхний 5 дугаар сарын байдлаар аймгийн хэмжээнд 3.6 мянган га-д үр тариа тариалалт хийсэн байна.

Сүхбаатар аймгийн хэмжээнд 2025 оны 5 дугаар сарын байдлаар төмс 20.0 га, хүнсний ногоо 5.1 га, үр тариа 3.6 мянган га, тэжээлийн ургамал 0.2 мянган га, техникийн ургамал 2.5 мянган га-д тариалсан байна.

Үр тариа 3.6 мянган га тариалснаас 3.6 мянган га улаан буудай, 20.0 га хөх тариа тариалсан байна.

ЗУРАГ 15.

НИЙТ ТАРИАЛСАН ТАЛБАЙ, га



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад төмс 9.7 (32.7 %) га-аар, хүнсний ногоо 8.4 (62.2%) га-аар, тэжээлийн ургамал 0.8 (80.0 %) мянган га-аар тус тус буурсан бол үр тариа 663 (22.4%) га-аар, техникийн ургамал 1.5 (2.5 дахин) мянган га-аар тус тус өсжээ.



АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 27.3 хувиар өслөө.


Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2025 оны эхний 5 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 122.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 26.3 (27.3%) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай олборлолт 26.6 (31.3%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 10. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар

Салбар	Жил		Сар		Өөрчлөлт	
	2023	2024	2024 I-V	2025* I-V	Дүн	Хувь
	сая төгрөг					
Нийт дүн	221 266.6	301 412.6	96 401.5	122 710.3	26 308.8	27.3
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	181 814.1	262 956.9	85 183.6	111 820.5	26 636.9	31.3
Боловсруулах аж үйлдвэр	29 791.3	26 755.2	4 921.5	3 614.8	-1 306.7	- 26.6
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	2 005.5	2 821.4	1 599.8	1 484.9	- 114.9	- 7.2
Усан хангамж, хог хаягдал зайлуулах, хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	7 655.6	8 879.1	4 696.6	5 790.1	1 093.5	23.3

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2025 оны эхний 5 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 111.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 26.6 (31.3%) тэрбум төгрөгөөр өсөхөд нүүрсний олборлолт 24.6 (2.1 дахин) тэрбум төгрөгөөр, бусад ашигт малтмал олборлолт 6.4 (49.5%) тэрбум төгрөгөөр өссөн нь тус тус нөлөөлсөн байна.

ЗУРАГ 15. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, жил бүрийн эхний 5 дугаар сарын байдлаар, тэрбум төгрөг



Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт хүрэн нүүрс, хайлуур жонш, хайлуур жоншны баяжмал 36.3 хувиас 2.9 дахин өсжээ.


Боловсруулах аж үйлдвэрийн салбарт бялуу, хэрчсэн гурил, адуу, үхэр, ямааны мах, цэвэр ус, бетон зуурмаг зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 10.8 хувиас 4.5 дахин өссөн байна.

ХҮСНЭГТ 11. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2024 V	2024 I-V	2025* V	2025* I-V	өөрчлөлт	
		тоо				дүн	хувь
Уул уурхай, олборлох аж үйлдвэр							
Хүрэн нүүрс	мян.т	175.5	696.0	-	976.6	280.6	40.3
Цайрын баяжмал	мян.т	6.2	24.5	5.0	21.0	-3.5	-14.3
Төмрийн хүдрийн баяжмал	мян.т	3.6	3.6	1.5	1.5	-2.1	-58.3
Хайлуур жонш	мян.т	0.7	3.0	1.4	8.7	5.7	2.9 ¹
Хайлуур жоншны баяжмал	мян.т	1.8	9.1	5.8	12.4	3.3	36.3
Боловсруулах аж үйлдвэр							
Талх	т	19.4	62.1	14.9	55.8	-6.3	-10.1
Нарийн боов	т	3.9	19.3	3.2	12.4	-6.9	-35.8
Хэвийн боов	т	0.4	19.3	0.8	11.5	-7.8	-40.4
Бялуу	т	0.3	1.3	0.3	1.6	0.3	23.1
Хэрчсэн гурил	т	0.0	0.2	0.1	0.4	0.2	2.0 ¹
Малын мах	т	-	493.4	-	251.6	-241.8	-49.0
Цэвэр ус	мян.л	64.2	287.2	64.8	318.2	31.0	10.8
Бууз, банш	т	0.3	5.1	0.4	1.5	-3.6	-70.6
Бусад төрлийн бэлтгэсэн хоол, хүнс	т	0.8	5.9	0.2	1.1	-4.8	-81.4
Бетон зуурмаг	м3	990	1 140	1 844	2 249	1 109	97.3

ЗУРАГ 16.

АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БОРЛУУЛАЛТ, жил бүрийн эхний 5 дугаар сарын байдлаар, тэрбум төгрөг



Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2025 оны эхний 5 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 173.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 38.4 (28.3%) тэрбум төгрөгөөр өслөө.

ХҮСНЭГТ 12.


АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар

Салбар	Жил		Сар		Өөрчлөлт	
	2023	2024	2024 I-V	2025* I-V	Дүн	Хувь
	сая төгрөг					
Нийт дүн	432 086.8	447 687.6	135 347.9	173 707.2	38 359.3	28.3
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	391 677.9	406 886.4	123 169.9	161 519.7	38 349.8	31.1
Боловсруулах аж үйлдвэр	29 697.8	27 053.5	5 013.6	3 759.5	-1 254.1	-25.0
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	2 453.5	3 893.7	2 098.4	2 066.9	-31.5	-1.5
Усан хангамж, хог хаягдал зайлуулах, хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	8 257.6	9 854.1	5 066.0	6 361.1	1 295.1	25.6

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 38.3 (31.1%) тэрбум төгрөгөөр өсөхөд хүрэн нүүрс олборлолт 37.9 (2.2 дахин) тэрбум төгрөг, бусад ашигт малтмал олборлолтын салбарын борлуулалт 5.1 (35.2%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

ЗУРАГ 17.

УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар, сараар, сая төгрөг



Гадаад зах зээлд 2025 оны эхний 5 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 159.8 тэрбум төгрөгийн борлуулалт хийсний 158.8 тэрбум нь уул уурхай, олборлох салбарын борлуулалт байна. Уул уурхайн бүтээгдэхүүний гадаад борлуулалтын 43.3 хувийг нүүрс олборлолтын салбар, 45.4 хувийг металлын хүдэр олборлолтын салбар, 11.3 хувийг бусад ашигт малтмал олборлолтын салбар эзэлж байна.

2025 оны эхний 5 дугаар сарын гүйцэтгэлээр 30.5 сая.квт.цаг эрчим хүчийг дамжуулан авч, 7.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн нийт үйлдвэрлэл 2025 оны эхний 5 дугаар сарын гүйцэтгэлээр 1.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.2 (27.3%) тэрбум төгрөгөөр өслөө. Иргэдийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 49.3 хувийг хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 28.0 хувийг хувцас үйлдвэрлэл, 12.9 хувийг мужааны зориулалттай модон эдлэл үйлдвэрлэл, 9.8 хувийг бусад үйлдвэрлэл эзлэж байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл нарийн боов, хэрчсэн гурил, цэвэр ус, монгол дээл, тэрлэг, дээлнээс бусад монгол хувцас, ажлын хувцас, гутал, модон сандал, гэрийн мод болон бусад хэрэгсэл зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1.2 хувиас 8.0 дахин өссөн байна.

СҮХБААТАР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Т.ЭРДЭНЭБАТ

Ойлголт, тодорхойлолт:

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

Тайлбар: Хувиараа үйлдвэрлэл эрхлэгч иргэн болон ААНБ-ын мэдээнд суурилсан гүйцэтгэл

Эх үүсвэр: Статистикийн хэлтэс, Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, борлуулалтын сарын мэдээ

Ангилал, код: Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал; Бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн ангилал;

БҮЛЭГ

ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭСЭН:

	Ерөнхий тэмдэглэл	
	Үндсэн үзүүлэлтүүд	
I	Хүн ам	С.Мөнхбаяр
II	Хөдөлмөр	Э.Анхцэцэг
III	Нийгмийн халамж	С.Мөнхбаяр
IV	Эрүүл мэнд	С.Мөнхбаяр
V	Гэмт хэрэг	Б.Сумъяа
VI	Мөнгө, банк	Б.Сумъяа
VII	Орон нутгийн төсөв	С.Мөнхбаяр
VIII	Үнэ	Б.Сумъяа
IX	Мал аж ахуй	О.Ундрах
X	Аж үйлдвэр	Э.Анхцэцэг
	Хавсралт хүснэгтийн жагсаалт	
	Хавсралт хүснэгтүүд	

ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН: Хэлтсийн мэргэжилтэн С.Мөнхбаяр

ХЯНАСАН: Ахлах мэргэжилтэн Э.Анхцэцэг

ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

II. ХӨДӨЛМӨР

-
-
- II.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар
 - II.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар, боловсрол, насны бүлгээр
 - II.3 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар
 - II.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АЖИЛД ОРСОН ХҮН, сумаар
 - II.5 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮН, сумаар
 - II.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮН, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, сумаар

III. НИЙГМИЙН ХАЛАМЖ

- III.1 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

IV ЭРҮҮЛ МЭНД

- IV.1 ЭРҮҮЛ МЭНД
- IV.2 ТӨРӨЛТ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар
- IV.3 ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧДИЙН ТОО, сумаар

V ГЭМТ ХЭРЭГ

- V.1 БҮРТГЭГДСЭН ХЭРЭГ
- V.2 БҮРТГЭГДСЭН ХЭРЭГ, сумаар
- V.3 СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИД
- V.4 СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИД, сумаар

VI МӨНГӨ, БАНК

- VI.1 ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, банкуудаар, сарын эцэст

VII ОРОН НУТГИЙН ТӨСӨВ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- VII.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО
- VII.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА
- VII.3 АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сумаар
- VII.4 АЙМГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, сумаар

VIII ҮНЭ

- VIII.a.1 ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС
- VIII.a.2 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ, хүнсний гол нэр төрлийн барааны дундаж үнэ
- VIII.6 МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, сумаар, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар

IX МАЛ АЖ АХУЙ

- IX.1 МАЛ ТӨЛЛӨЛТ, сумаар
- IX.2 ТӨЛ БОЙЖИЛТ, төрлөөр
- IX.3 ТӨЛ БОЙЖИЛТ, сумаар
- IX.4 ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, сумаар
- IX.5 ТАРИАЛСАН ТАЛБАЙ, сумаар, га-р

X АЖ ҮЙЛДВЭР

- X.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, дэд салбараар
- X.2 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, дэд салбараар
- X.3 АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, дэд салбараар
- X.4 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, дэд салбараар
- X.5 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, нэр төрлөөр
- X.6 ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ ИРГЭДИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, БОРЛУУЛАЛТ
- X.7 ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ ИРГЭДИЙН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, нэр төрлөөр

II. ХӨДӨЛМӨР

- II.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар

Сум	2023		2024		2025	өөрчлөлт	
	V	XII	V	XII	V	дүн	хувь
	тоо						
Нийт дүн	-	302	175	234	283	108	61.7
Асгат	-	2	9	12	5	-4	- 44.4
Баяндэлгэр	-	8	-	1	-	-	-
Дарьганга	-	3	1	2	2	1	2.0 ¹
Мөнххаан	-	83	1	21	4	3	4.0 ¹
Наран	-	4	3	5	3	-	-
Онгон	-	2	-	2	2	2	-
Сүхбаатар	-	7	6	1	27	21	4.5 ¹
Түвшинширээ	-	3	5	15	32	27	6.4 ¹
Түмэнцогт	-	2	3	16	4	1	33.3
Уулбаян	-	26	2	2	6	4	3.0 ¹
Халзан	-	-	-	8	4	4	-
Эрдэнэцагаан	-	33	20	-	7	-13	- 65.0
Баруун-Урт	-	129	125	149	187	62	49.6

II.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар, боловсрол, насны бүлгээр

Сум	Бүгд	эмэгтэй	Боловсролын түвшингээр									Насны бүлгээр					
			Магистр, доктор	Дээд боловсролтой	Тусгай дунд боловсролтой	Мэргэжлийн анхан шатны	Бүрэн дунд боловсролтой	Суурь	Бага	Боловсролгүй	15-24	25-34	35-44	45-54	55-59	60+	
			Тоо														
Нийт дүн	283	135	3	37	10	9	122	64	29	9	12	83	92	63	21	12	
Асгат	5	3	-	3	-	1	1	-	-	-	1	-	4	-	-	-	
Баяндэлгэр	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	
Дарьганга	2	-	-	1	-	-	1	-	-	-	-	-	1	1	-	-	
Мөнххаан	4	-	-	-	-	1	1	2	-	-	-	2	1	1	-	-	
Наран	3	-	-	-	1	1	-	1	-	-	-	1	-	1	-	1	
Онгон	2	-	-	1	-	-	1	-	-	-	-	1	-	1	-	-	
Сүхбаатар	27	14	1	4	-	1	9	8	2	2	-	10	5	9	1	2	
Түвшинширээ	32	14	-	1	1	-	2	15	12	1	-	6	14	7	3	2	
Түмэнцогт	4	1	-	2	-	-	2	-	-	-	-	1	2	1	-	-	
Уулбаян	6	2	-	-	-	-	1	3	2	-	-	2	3	1	-	-	
Халзан	4	1	-	1	-	-	2	1	-	-	-	-	-	2	1	1	
Эрдэнэцагаан	7	3	-	-	-	-	2	3	2	-	-	2	2	2	1	-	
Баруун-Урт	187	97	2	24	8	5	100	31	11	6	11	58	60	37	15	6	

Сум	2023		2024		2025	өөрчлөлт	
	I-V	I-XII	I-V	I-XII	I-V	дүн	хувь
	тоо						
Нийт дүн	581	1 870	348	1 874	716	368	2.1 ¹
Асгат	13	70	13	159	21	8	61.5
Баяндэлгэр	3	33	-	62	-	-	-
Дарьганга	14	96	9	138	8	-1	-11.1
Мөнххаан	4	96	17	87	18	1	5.9
Наран	29	76	21	79	24	3	14.3
Онгон	20	135	1	85	5	4	4.0 ¹
Сүхбаатар	53	106	7	51	61	54	7.7 ¹
Түвшинширээ	124	184	8	165	68	60	7.5 ¹
Түмэнцогт	3	44	5	76	12	7	2.4 ¹
Уулбаян	18	88	2	32	7	5	2.5 ¹
Халзан	-	31	2	26	15	13	6.5 ¹
Эрдэнэцагаан	16	171	36	72	9	-27	-75.0
Баруун-Урт	284	740	227	842	468	241	2.6 ¹

II.3 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар

II.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АЖИЛД ОРСОН ХҮН, сумаар

Сум	2023		2024		2025	өөрчлөлт	
	I-V	I-XII	I-V	I-XII	I-V	дүн	хувь
	тоо						
Нийт дүн	46	764	121	1 022	401	280	3.3 ¹
Асгат	12	62	3	120	19	16	6.3 ¹
Баяндэлгэр	-	22	-	60	-	-	-
Дарьганга	4	73	8	133	5	-3	-37.5
Мөнххаан	1	9	24	79	15	-9	-87.5
Наран	4	35	18	55	20	2	11.1
Онгон	8	97	1	83	1	-	-
Сүхбаатар	-	43	1	4	32	31	32.0 ¹
Түвшинширээ	-	48	3	126	37	34	12.3 ¹
Түмэнцогт	-	32	-	51	4	4	-
Уулбаян	-	44	-	21	1	1	-
Халзан	-	31	2	18	11	9	5.5 ¹
Эрдэнэцагаан	4	114	18	41	2	-16	-88.9
Баруун-Урт	13	154	43	231	254	211	5.9 ¹

II.5 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮН, сумаар

	2023 I-V				2024 I-V				2025 I-V				өөрчлөлт	
	Бүгд	Байнгын	Түр	Улирал	Бүгд	Байнгын	Түр	Улирал	Бүгд	Байнгын	Түр	Улирал	дүн	хувь
тоо														
Нийт дүн	-	-	-	-	49	29	17	3	51	17	13	21	2	4.1
Асгат	-	-	-	-	2	2	-	-	4	-	4	-	2	2.0 ¹
Дарьганга	-	-	-	-	11	8	1	2	3	1	2	-	-8	-72.7
Наран	-	-	-	-	17	1	16	-	4	-	4	-	-13	-76.5
Түвшинширээ	-	-	-	-	-	-	-	-	8	3	3	2	8	-
Уулбаян	-	-	-	-	-	-	-	-	6	3	-	3	6	-
Халзан	-	-	-	-	-	-	-	-	6	6	-	-	6	-
Эрдэнэцагаан	-	-	-	-	19	18	-	1	1	1	-	-	-18	-94.7
Баруун-Урт	-	-	-	-	-	-	-	-	19	3	-	16	19	

II.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮН, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, сумаар

Сум	2025 I-V		Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар									
	Бүгд	Эмэгтэй	Хөдөө аж ахуй, ойн аж ахуйн, загас агнуур	Боловсруулах үйлдвэр	Барилга	Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	Мэдээлэл, холбоо	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	Урлаг, үзвэр, тоглоом наадам	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн өөрийн хэрэгцээнд зориулан үйлдвэрлэсэн хэмжээг нь тодорхойлох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ
	Тоо											
Нийт дүн	51	23	4	1	5	18	6	13	1	1	1	1
Асгат	4	2	-	-	2	-	-	1	1	-	-	-
Дарьганга	3	3	1	-	-	-	-	2	-	-	-	-
Наран	4	1	-	-	3	-	-	-	-	1	-	-
Түвшинширээ	8	6	2	-	-	-	-	5	-	-	-	-
Уулбаян	6	2	1	-	-	-	-	4	-	-	1	1
Халзан	6	5	-	-	-	-	6	-	-	-	-	-
Эрдэнэцагаан	1	1	-	1	-	-	-	-	-	-	-	-
Баруун-Урт	19	3	-	-	-	18	-	1	-	-	-	-

III. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

III.1 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	2023 I-IV		2024 I-IV		2025 I-IV		Өөрчлөлт	
	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг	Дүн	Хувь
Бүгд	22 792	5 040.7	23 408	6 710.1	19 023	8 321.3	1 611.2	24.0
Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, үйлчилгээ	4 499	2 874.5	4 608	4 623.1	4 974	5 569.1	946.0	20.5
Нийгмийн халамжийн тэтгэвэр	1 360	1 933.9	1 454	2 448.2	1 486	2 899.8	451.6	18.4
Нийгмийн халамжийн тэтгэмж	2 130	855.9	2 469	2 135.6	2 814	2 629.3	493.7	23.1
Асаргааны тэтгэмж	1 073	477.7	1 279	1 670.7	1 425	2 060.8	390.1	23.3
Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	193	78.7	212	283.9	247	361.2	77.3	27.2
